



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/199

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Гишүүд: Э.Буянтогтох (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Б.Пүрэвсүрэн (Нягтлан бодогч)

2.Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Н.Түвшин)-д даалгасугай.

ДАРГА



С.АМГАЛАН